

**“Нако түлш” ХК-ийн 2014 оны  
үйл ажиллагааны тайлан**

Компанийн нэр: ”Нако түлш” ХК

Хаяг: Дархан-Уул аймаг, Дархан сум, Үйлдвэрийн хотхон 13-р баг

Утас:70379006

Улсын бүртгэлийн дугаар:	1910001019
Регистрын дугаар:	4489969
Үйл ажиллагааны чиглэл:	Хагас коксон утаагүй түлшний үйлдвэрлэл
Хувьцаа эзэмшигчдийн тоо:	128 /2015.03.06-ны байдлаар/

Үйл ажиллагааны тайлан:

“Нако түлш” ХК 2014 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Зуухны доод амнаас коксыг жигд буулгах зорилгоор кокс буух хэсгийн налууг нэмэгдүүлсэн. Зуухны ёроолын налуу бага байснаар галын бүсэд хэт удаан байсан нүүрсэн дэх холц шавар, чулуу хайлж барьцалдан хананд наалдаж зуух шланкдах байдал эрс багасна.
- Насос бүхий 7 тоннын тосны нөөцийн сав байрлуулсан. Гар ажиллагааг хөнгөвчлөх, тосноос үүдсэн орчны бохирдлыг багасгах, тос авалтын хоорондын хугацаа уртсах давуу талтай болсон.
- Зуух ачааллах хэсгийг өөрчилж, нөөцийн бункер бүхий элеватор, конвейер хосолсон ачаалагчийг суурилуулсан. Ачаа унах эрсдэлийг бууруулах, зуухны орой дахь нөөцийн бункерээс маш богино хугацаанд зуухыг ачааллах боломжтой болсон.
- Коксын 210м<sup>2</sup>талбай, нүүрсний 480м<sup>2</sup> талбайг нэмж бетондсон. Нүүрс болон хагас кокс буух бетон талбайг нэмэгдүүлсэн.
- Коксын хос зуухны хөргөлтийн системийг сайжруулах ажлын хүрээнд зураг төсөл хийлгэж хос насос бүхий хөргөлтийн усан сан барьсан. Коксын хос зуух зэрэг ажиллах тохиолдолд хөргөлтийн системийн хүчин чадал хүрэлцэхгүй байсныг бүрэн шийдвэрлэж чадсан.
- Хагас коксын зуух, шатдаг хийн байгууламжийн гадуур шилэн хөвөн бүхий сендвич барилга барьсан. Хүйтний улиралд гадаа ажиллахгүй, хөргөлтийн усны шугам хоолой хөлдөхгүй байх, аль ч улиралд ажиллах боломжтой болсон.
- Ажилчдын хувцас солих өрөөг өргөтгөж ашиглалтанд оруулсан. Барилгыг өргөтгөснөөр40-50 хүнийг хувьцас солих, усанд орох боломжоор хангасан.
- Коксын 1-р конвейерийг хажуу тийш 15 метр шилжүүлж, коксын 2-р конвейерийн чиглэлийг өөрчлөх ажлыг хийсэн. Конвейерүүдийг шилжүүлснээр талбай ашиглалтыг нэмэгдүүлж, брикетэн цех, агуулахын барилга барих талбайг чөлөөлсөн.
- Зуухны агаар өгөх 3 вентиляторыг барилгын гадна монтажилж дуу чимээ ихтэй вентиляторуудыг барилгын гадна гаргасан.

- Үйл ажиллагааны борлуулалтын орлого 2014 онд 862,3 тн нунтаг нүүрс, 316,5 тн хагас кокс, 490,7 тн бүхэл нүүрс борлуулсан байна. Борлуулалт 2014 онд өмнөх онтой харьцуулахад 104047,3 мянган төгрөгөөр өссөн байна.

**Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд:**

Тус компани нь 2014 оны 12-р сарын 31-ны өдрөөр дуусгавар болгон санхүү байдлын тайлан, орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан тэнцлээ Олон улсын стандарт болон Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн хууль түүнд нийцүүлэн гаргасан журам, заавар, аргачлалаар мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу гарган санхүү, татварын байгууллага болон холбогдох бусад газруудад тушаасан. Хараат бус аудитын итгэмжлэгдсэн байгууллага “Голден пэйж аудит” ХХК-иар хянуулан баталгаажуулсан.

Компанийн 2013, 2014 оны жилийн орлогын тайлангийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

Үзүүлэлт	2013 он	2014 он
Борлуулалт	6503,3	110550,6
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	9797,1	185592,5
Нийт ашиг	-3293,8	-75041,9
Үйл ажиллагааны бус орлого	2319,2	4727,5
Үйл ажиллагааны зардал	123349,3	283375,2
Үйл ажиллагааны бус зардал	75538,6	51512,3
Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал	-199862,5	-405201,9
Орлогын татварын зардал	156,8	38,2
Цэвэр ашиг, алдагдал	-200019,4	-405240,1

Үйл ажиллагааны борлуулалтын орлого 2014 онд “Тэгш хан” ХХК-д 150,4 тн, “Эрэл цемент”-ийн үйлдвэрт 711,9 тн нунтаг нүүрс, “Шарын гол-Энерго” ХХК-д 316,5 тн хагас кокс, бусад хэрэглэгчдэд 490,7 тн нүүрс борлуулсан байна. Борлуулалт 2014 онд өмнөх онтой харьцуулахад 104 047,3 мянган төгрөгөөр өссөн байна. Мөн үйл ажиллагааны бусад зардалд 2 Pak Resources Investments SARL компаниас авсан долларын зээлийн ханшийн зөрүүний бодит бус алдагдал 50834,7 мянган төгрөг байна.

Цалин хөлсний зардалд 84 410,0 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 20 789,0 мянган төгрөг, ашиглалтын зардалд 371 548,6 мянган төгрөг, түлш шатахуун, тээврийн хөлс сэлбэг хэрэгслийн зардалд 11 284,4 мянган төгрөг, ХХОАТ 16 798,4 мянган төгрөг тус тус зарцуулсан байна. Компаний үндсэн хөрөнгөд сэндвичэн барилга баригдаж, эльватор, конвейер, бункер, хөргөлтийн системийг хийж суурилуулсан. Нийт шинээр нэмэгдсэн хөрөнгийн өртөг 163 671,1 мянган төгрөг байна.

Компанийн 2013 он, 2014 оны хөрөнгө, эх үүсвэрийн тэнцлийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

Хөрөнгө өр төлбөрийн үзүүлэлтүүд	2013 он	2014 он
Эргэлтийн хөрөнгө	698389,8	595958,3
Эргэлтийн бус хөрөнгө	2741147,6	2909308,8
Нийт хөрөнгийн дүн	3439537,4	3505267,1
Богино хугацаат өр төлбөр	906592,6	1045310,2
Урт хугацаат өр төлбөр	362972,5	695224,7
Эзэмшигчийн өмчийн дүн	2169972,3	1764732,2
Өр төлбөр, эзэмшигчийн өмчийн дүн	3439537,4	3505267,1

Үнэт цаас гаргагчийн хяналтын багц эзэмшигчдийн болон ТУЗ-ийн мэдээлэл:

Компани их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгээгүй. Компанийн хяналтын багц эзэмшигчдийн хувьд өөрчлөлт ороогүй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Б.Батбаатар, Грам Чапман, Б.Баярбат, Ж.Эрдэмбилэг, Д.Даянбилгүүн, Б.Лхагвадорж, хараат бус гишүүдээр Д.Нарангоо, Т.Тамир, Д.Түвшинтөгс нар ажиллаж байна.

№	Овог нэр	Албан тушаал	Боловсрол
1	Б.Батбаатар	ТУЗ-ийн дарга	Дээд
2	Грамм Чапман	ТУЗ-ийн ердийн гишүүн	Дээд
3	Б.Баярбат	ТУЗ-ийн ердийн гишүүн	Дээд
4	Ж.Эрдэмбилэг	ТУЗ-ийн ердийн гишүүн	Дээд
5	Д.Даянбилгүүн	ТУЗ-ийн ердийн гишүүн	Дээд
6	Б.Лхагвадорж	ТУЗ-ийн ердийн гишүүн	Дээд
7	Д.Нарангоо	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Дээд
8	Т.Тамир	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Дээд
9	Д.Түвшинтөгс	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Дээд
10	Ж.Энхцэцэг	ТУЗ-ийн нарийн бичиг	Дээд

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал нар 100 хувь компанийн засаглалын сургалтанд хамрагдсан.

Компаний хувьцаа эзэмшигчдийн 2014 оны ээлжит хурлыг хуульд заасан хугацаа, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журамд заасан шаардлагад нийцүүлэн “Нако Түлш” ХК 2014 оны 04 сарын 22-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулж дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2013 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
3. 2014 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2014 оны зардлын төсвийг батлах
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах

Хурлаар хэлэлцсэн асуудлуудыг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар баталсан

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгосон бөгөөд 2014 оны 05 сарын 22-ны өдөр Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулан ТУЗ-ийн дэргэдэх хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсон.

А. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын дэд хороог Т.Тамир, Д.Даянбилгүүн, Д.Нарангоо гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Аудитын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус Т.Тамир гишүүнийг томилсон.

Б. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Цалин урамшууллын дэд хороог Грам Чэпмэн, Т.Тамир, Д.Түвшинтөгс гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Цалин урамшууллын дэд хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Грам Чэпмэн-г томилсон.

В. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх дэд хороог Ж.Эрдэмбилэг, Т.Тамир, Д.Нарангоо гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Нэр дэвшүүлэх дэд хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Ж.Эрдэмбилэгийг томилсон.